



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 06 өдөр

Дугаар А/01


Номгон

Монголын хүүхдийн спортын VII наадмыг
зохион байгуулах тухай

Биеийн тамир, спортын улсын хорооны 2022 оны Монголын хүүхдийн спортын зуны VII наадмыг 2023 онд зохион байгуулах эрх олгох тухай А/209 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангуулах зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Спортын наадам хойшлуулах тухай" 268 дугаар тогтоол, 2018 оны 183 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөг батлах тухай 12/54 дүгээр тогтоолын хавсралтын 1.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын хүүхдийн спортын VII наадмын шигшээ тэмцээнийг 2023 оны 06 дугаар сарын 19-29 -ний өдрүүдэд зохион байгуулсугай.
2. Хүүхдийн спортын VII наадмыг зохион байгуулах хороог хавсралтаар баталсугай.
3. Дээрх үйл ажиллагаанд зарцуулагдах 80.000.000 (наян сая) төгрөгийг Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.
4. Монголын хүүхдийн спортын VII наадмын шигшээ тэмцээнийг удирдамжийн дагуу өндөр түвшинд зохион байгуулж, Баянхонгор аймгийн шигшээ баг тамирчдыг бэлтгэн оролцуулахыг Биеийн тамир, спортын газар /Б.Оюунбаатар/-т, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Наранбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.
5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

642310001

Аймгийн Засаг даргын 023 оны 01 дүгээр
сарын 02 ны өдрийн 1101 дүгээр захирамжийн
хавсралт

ХҮҮХДИЙН СПОРТЫН VII НААДМЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРОО

Хорооны дарга:	Б.Батсуурь	Аймгийн Засаг даргын орлогч
Гишүүд:	Д.Сарангарав	Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
	П.Отгонбаяр	Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн Дарга
	С.Байгалмаа	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	Б.Наранбаяр	Нийгмийн бодлогын хэлтийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Т.Хишигбаатар	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
	Г.Нэмэхбаяр	Аймгийн Засаг даргын тамгын газрын Цэргийн штабын дарга, хурандаа
	Д.Монголжийбуу	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Соёл, спорт хариуцсан мэргэжилтэн
	Б.Мөнхбаяр	Цагдаагийн газрын дарга, дэд хурандаа
	Ж.Алтангэрэл	Онцгой байдлын газрын дарга, хурандаа
	Н.Энхжаргал	Эрүүл мэндийн газрын дарга
	Ц.Азбаясгалан	Соёл, урлагийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Ж.Алтанцэцэг	Боловсрол шинжлэх ухааны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Н.Мэндбаяр	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга
	Ж.Уламбаяр	"Баянхонгор-Эрчим хүч" ЦТ ХХК-ний дарга
	Г.Энхбаяр	Баянхонгор сумын засаг дарга бөгөөд Хотын Захирагч

2.

С.Амармөнх Авто тээврийн үндэсний төвийн Баянхонгор аймаг дахь салбарын дарга

Т.Отгонбаатар "Баянхонгор Тохижилт Үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын захирал

У.Балжинням Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Д.Дэлгэрсайхан Засаг даргын тамгын газрын Хэвлэл мэдээллийн ажилтан

Нарийн бичгийн дарга

Б.Оюунбаатар Биеийн тамир, спортын газрын дарга

_____оОо_____